



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/208

Улаанбаатар хот

“Хуулийн этгээд, түүний салбар,
төлөөлөгчийн газрын улсын бүртгэл
хөтлөх журам батлах тухай”

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар /Б.Баасандорж/-т, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Хууль зүйн сайдын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/39, А/40 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Ц.НЯМДОРЖ